

Living the LOTUS

Buddhism in Everyday Life



Үүсгэн байгуулагчийн сургаал

Хүний уужим сэтгэл

Хүнд хамгийн сайн хат суулгадаг зүйл бол өөрийг нь эсэргүүцдэг, хэлсэн үгийг нь хүлээж авдаггүй хүнтэй учрах явдал юм. Тийм хүнтэй учрах үед “хүн гэдэг санаснаар болдоггүй юм байна” гэж бодно.

Юу ч байсан “за” гээд хэлсэн бүгдийг сонсдог хүнээс ялгаатай нь хийсэн болгоныг эсэргүүцэж, үгнээс өө хайж байгаа хүнийг хүлээн авч, “аяж ийж байгаад энэ хүнд өөрийгөө зөвөөр ойлгуулах юмсан” гэж хянуур хандаад эхлэхээр тэрхүү эсэргүүцлийн ард нөгөө хүний уйтгар гуниг, дорой байдал харагдаад ирдэг. Тэр сэтгэл

нь харагдаад эхлэхээр бусдын асуудал биш болдог.

Ер нь янз бүрийн хүмүүстэй муудалцаж, харилцаж үзэж байж “хүний сэтгэл гэж ямар зүйл болохыг” таньдаг ба ингээд ирэхээр хүн хүлээцтэй тайван болдог. Мөн ямар ч хүнээс айхааргүй болно. Энэ нь сэтгэлийг уужим болгоход нөлөөлдөг.

Бусдын сэтгэлийг ойлгохгүйгээр жинхэнэ энэрэл төрж гарахгүй. Улмаар хүмүүс чамд итгэж, хүрээлэхгүй.

Living the Lotus Vol. 153 (June 2018)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Sugunami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Саитоо Кооичироо

Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Б. Мөнхцэцэг

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдрал)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туульцаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Түр азнах

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Юуны түрүүнд амьсгаа авцгаая

Өнөө үед хадгалагдаж үлдсэн судраас хамгийн эртнийх болох Дармапада (Номын шүлэг) сударт: “Эрчээ аван давхих тэргийг зогсоох лугаа уур хилэнгээ барьж чаддаг хүн- түүнийг <жолоодогч> хэмээн дуудмой” (Накамүра Хажимэгийн орчуулга/Иванами хэвлэлийн газар) гэдэг нэг мөр байдаг.

Шагжамүни Бурхан багш уур хилэнгээ хянах нь ямар чухал болохыг ийнхүү сургажээ. Гэсэн хэдий ч сэтгэлээ барих нь тун амаргүй зүйл юм. Энэ нь ганц уур хилэнгээ барихаар хязгаарлагдахгүй. Хэлэх хэрэггүй үгийг хэлж, элдэв хэв маягт хууртагдаад авах шаардлагагүй зүйлийг худалдан авч, өөрийн баримталдаг зүйлээсээ гадуур зүйл хийгээд, түүнээсээ болж бусадтай маргалдаж орхидог нь хүмүүс бидний гэм биш зан.

Тэгвэл уур хилэн, шунал, мунхаг гуравтаа ялагдах гээд байгаа үед явал зогсоож чадах вэ?

Миний хувьд эхлээд “гүнзгий амьсгаа авах” гэдгийг та бүгдэд зөвлөмөөр байна. Нэг удаа гүнзгий амьсгаа авах төдийд сэтгэл санаа багагүй тайвширна. Чадвал нэг шөнийн турш тайван бодоод үзэх хэрэгтэй.

Хэрэв шашин шүтлэгтэй хүн бол сэтгэлд уур, шунал, мунхагийн хар үүл бүрхээд ирвэл “Бурхан багш байсан бол юу гэж бодох байсан бол?”, “юу хийх байсан бол?” гэх зэргээр бодоод үзвэл сэтгэл тайвширч, эргээд хэвийн байдалдаа орж болно. Эсвэл заавал бурхан шиг нэгэн байх албагүй. “Аав минь байсан бол яах байсан бол?”, “ээж минь байсан бол...” гэх мэтээр ойр дотны хүмүүсээ бодохоор сэтгэл нь тайвширч, уур хилэн нь дарагддаг хүн ч байж болно.

“Хутагтын найман зөв зам”-ын хоёрдугаарт гардаг “зөв бодол” нь “уур хилэн, шунал, мунхагаас салж, бурхан багш шиг уужим сэтгэлээр бодох” гэсэн үг юм. Үүнийг амьдралд ойроор хэлвэл уур хилэн, сэтгэл хөдлөлд хэт автах гээд байвал эхлээд “нэг амьсгаа” аваад түр азнах, энэ нь сэтгэлээ жолоодож сурах эхлэл болох болов уу.

Энэрэнгүй сэтгэлээр

Шунал, уур хилэн, мунхаг (хувиа хичээсэн үзэл) хэмээх “сэтгэлээр үйлдэх гурван нүгэл”-ийг гээж, уужим сэтгэлээр бодох - ингэж чадвал маш сайн гэдгийг бүгд мэднэ гэж бодож байна. Гэвч “ийм хүн болцгооё”, “шуналаасаа салцгаая” гэж сонсох тусам “яаж ч хичээсэн шунал, уур, мунхагаасаа салж чаддаггүй муу хүн гэж өөрийгөө бодоход хүрдэг” гэх шантарсан үгийг сонсож байсан удаатай.

Харах өнцөгөө өөрчлөөд “зөв бодол”-ын утгыг сайтар тунгааж, ойлголтоо илүү гүнзгийрүүлээд үзэцгээе.

Шуналгүй, уур хилэнгүй, бусдыг үл тоосон сэтгэлгүй байна гэдэг “зөв бодол = зөв бодож тунгаах” гэсэн утгатай болох бөгөөд үүнийг “бусдыг ойлгох”, “ээлдэг зөөлнөөр хандах”, “өрөвдөн энэрэх сэтгэл”-ээр бодох, гэж хэлж бас болно. Дээр дурьдсаныг нэг үгээр хэлбэл “энэрэнгүй сэтгэл” юм. Өөрөөр хэлбэл энд дурьдагдаж буй “зөвөөр” гэдэг нь “энэрэнгүй сэтгэлээр” гэсэн утгатай болно.

Төгс хүн гэж байхгүй. Тиймээс хааяа шунал хүрч, уур цухалдал төрж байсан ч “энэрэнгүй сэтгэлээр бодох” хэвшлийг бий болгох нь чухал гэсэн үг юм.

Тэгэж чадвал хэн ч байсан бурхан багш шиг уужим сэтгэлээр бодож, үйлдэж чадна. Гэхдээ хүний амьдралд дээрхийн адил хэрэгжүүлэхэд бэрх үе нэг бус удаа тохионо.

Өмнө нь “чимээгүйхэн нар лугаа, салхи лугаа, багана лугаа, чулуу лугаа” гэсэн үгний тухай ярьж байсан. Харилцааны асуудлаас болоод сэтгэл хөдлөлд хүчтэй автах гээд байгаа үед дээрх үг шиг нам гүм байгаль дэлхийн хувиралыг бодож, сэтгэлийнхээ хил хязгаарыг даваад үзэцгээе. Газар тэнгэр, байгаль болоод хүмүүс бид нэгэн бүхэл юм. Үүний адил эргэн тойрны хүмүүстэйгээ нэгэн бүхэл -гэдгээ анзаарах юм бол бид бүхэн өөрийн сэтгэлийн “жолоодогч” нь болж чадна. Бурхан багш шиг агуу уужим сэтгэлээр, талархал дүүрэн амьдралаар амьдарч чадна.

“Косей” сэтгүүл 6-р сарын дугаараас





Одоо цагтаа төвлөрч амьдрах нь



Бангладеш нийгэмлэг, салбарын ахлагч
Бимал Канти Баруа

Энэхүү илтгэл 2018 оны 4 сарын 20-нд Бангладеш нийгэмлэгт зохион байгуулагдсан номын хурал дээр тавигдсан болно.

Та бүгдэд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Намайг Бимоорү Канти Боруа гэдэг. Эхнэр, охин, хүүгийн хамт аз жаргалтай амьдарч байна. Одоо Өмнөд Читтагон салбарын ахлагчийн үүргийг гүйцэтгэж байгаа.

Илтгэл тавих үүргээр дамжуулж, өөрийнхөө амьдралыг эргэн харж, эргэцүүлэх боломж олгосон Аритомит тэргүүн болон Бангладеш нийгэмлэгийн лидер гишүүдэд талархалаа илэрхийлье.

Мөн илтгэлийнхээ эхэнд намайг тус нийгэмлэгт хөтлөн ирж, гишүүнээр элсүүлсэн Бипроп Боруад чин сэтгэлээсээ талархал илэрхийлье. 2000 онд тэрээр над дээр хэд хэдэн удаа ирж, РКК-н гайхалтай сургаалыг

танилцуулсан. Мөн Бангладешт РКК-н сургаалыг анх түгээсэн Бииман Күмаар Боруагийн гэрт намайг дагуулж очиж байсан.

РКК-н сургаал анх Бангладешт дэлгэрэх үед хамтдаа зүтгэж байсан номын андуудаас олон хүн одоо бурхан болжээ. Бурханы авралаар миний бие эрүүл саруул ийнхүү салбарын ахлагчийн үүргийг гүйцэтгэж байгаадаа талархаад баршгүй.

Би ажлын шаардлагаар Японд удаан хугацаагаар амьдарч байсан ба нутагтаа буцаж ирснээсээ хойш Японы талаар сонирхон судалдаг байсан боловч РКК-н талаар огт мэддэггүй байлаа. Гэвч элсээд удаагүй хүн эсвэл лам бус хүн ч бай бурханы сургаалыг суралцаж, бусдад түгээх боломжтой гэдгийг мэдээд РКК бол үнэхээр анхаарал татмаар байгууллага юм байна гэж бодсон.

Гишүүнээр дөнгөж элсээд байхдаа би гэрлээд удаагүй байлаа. Бал сарын аялалаар Сингапур, Тайланд, Балба, Энэтхэг рүү явсан юм. Балбад явж байхдаа Сайрэндра салбарын ахлагчтай уулзах завшаан тохиосон юм. Тэр үед ахлагчаас мөн РКК байгууллагын тухай сонсов. Буцах замдаа Колкатад амьдардаг хамаатныхаараа дайрсан ба ахлагчаас сонссон зүйлсээ өөрийнхөөрөө дамжуулав. Хожим нь тэрхүү хамаатан маань ч гишүүнээр элссэн.

Бал сарын аялалаас харьж ирэхэд Японоос нэг хүн ирсэн гэж сонсов. Ингэж би Иизава гуайтай анх уулзаж байсан түүхтэй. Япон хэлээр бага зэрэг ярьдаг байсан тул Иизава гуайг дагаад айлуудаар сургаал түгээн явдаг байв. Улмаар гишүүдийн тоо нэмэгдэж, 300 давсан тул Иизава гуай Япон дахь төв лүү холбогдож, сүм барих газар худалдаж авч өгөхийг хүссэн юм. Тохирох газар хайж байхдаа одоогийн сүмийн газрыг танилцуулж өгсөн Шёнжит Боруа Бүрүтэй



Бимал Канти Баруа илтгэл тавьж байгаа нь

танилцаж байв. Тэрээр одоо бурхан болсон хэдий ч надад байнга тусалдаг үнэхээр сайн хүн байсан.

Гишүүнээр элсэхийн өмнө би үргэлж өөрийнхөө зөв гэдэгт бат итгэдэг хүн байлаа. Тиймээс ч бусадтай үзэл бодол таарахгүй маргалдах үе цөөнгүй тохиолддог байв. Мөн буддизмын олон урсгалуудыг хооронд нь харьцуулж их бодно. РКК-н гишүүн болсноороо буддизмын сургаалуудыг хооронд нь харьцуулах шаардлагагүй гэдгийг ойлгосон юм. Түүнчлэн РКК-н сургаал бол хэрэгжүүлж чадах зүйлээсээ хэрэгжүүлэх нь чухал гэдгийг ойлгоод РКК-н сургаалыг улам гүнзгийрүүлэн суралцахыг хүсэх болсон. Тухайн үед Канчан Боруа Японы төвд байрладаг Гакүрин сургуульд 2 жил сураад төгсөж ирээд байв. Түүнээс РКК-н сургаал, дэг жаягийн талаар маш ихийг сураад сэтгэл хөдөлж, өшөө олон хүнд энэ гайхалтай сургаалыг дамжуулж, түгээхийг хүсэх болов. Дараагаар нь Их ариун ордноос бурхан залж, номын багшийн эрхийг хүлээн авч, эхлээд шүнин, харин одоо салбарын ахлагчийн үүргийг хүлээж аваад байна. Үүргүүдийг гүйцэтгэж байх явцад хүнд сургаалыг дамжуулах нь амаргүй даалгавар гэдгийг сайн ойлгосон ба амьдрал гэдэг үргэлж сайхан зүйлээр дүүрэн байдаггүйг ойлгосон. Хүн амьдарч л байвал төрөл бүрийн бэрхшээл зовлонтой нүүр тулахаас өөр аргагүй болдог. Миний амьдралд тохиолдсон олон бэрхшээлүүдийн дотроос нэгийг нь өнөөдөр та бүхэнтэй хуваалцъя.

Тэр үед би хувцасны үйлдвэр эрхэлдэг байв. Бизнес маань амжилттай явагдахгүй байсаар их хэмжээний өрөнд орсон юм. Хичнээн бодсон ч гарц харагдахгүй, нүдний өмнөх бүхэлдээ харанхуй юм шиг санагдана. Орлого гэхээр зүйл бараг байхгүй байсан тул гэр бүлээ тэжээхэд ч бэрх байлаа. Гэтэл дайран дээр давс гэгчээр өөр асуудалтай тулгарав. Эрэгтэй дүү маань өмнө нь дундаасаа мөнгө гарган барьсан байшингийн барилгын тал мөнгийг төлөхгүй бол өөр хүнд зарлаа гэж хэлэх нь тэр. Гэр бүлээ хамгаалах үүрэгтэй би яахаа мэдэхгүй шаналж байхад РКК-н номын андууд минь үргэлж хажууд байсан.

Номын андуудынхаа халуун дэмжлэг, шуурхай тусламжийн ачаар сэтгэл хөнгөрсөн. Мөн тухайн үед явагдаж байсан Аритомид тэргүүний сургалтанд суусан юм. Тэр үед Аритомид тэргүүн өөрийнхөө өрөнд орж байсан тухайгаа ярьсан. “Аливаа зүйл санаснаар болохгүй нь мэдээжийн зүйл юм. Тиймээс өнгөрсөн зүйлийг бодож цагаа дэмий үрэхийн оронд одоо цагаа чухалчилж, одоо цагтаа төвлөрч амьдрах нь чухал”. Үргэлжлүүлээд Аритомид тэргүүн голын урсгалаар зүйрлэн ойлгоход хялбараар тайлбарлав.

“Голын эхээс бохир ус урсан ирлээ гэж бодъё. Бохир усыг дунд хэсэгтээ цэвэрлэж чадвал голын адаг руу бохир ус урсахгүй. Үүнтэй ижил өнгөрсөнд юу ч тохиолдсон бай, одоо цагтаа төвлөрч, хийх ёстой зүйлээ хийвэл, гэрэлт ирээдүй угтаж авах нь дамжиггүй.”

Тэргүүний яриаг сонсоод өөрт тохиолдоод буй асуудлыг шийдэх гарц харагдах шиг болов. Одоо цагтаа төвлөрч, асуудлаа шийдэхийн төлөө хичээж, чадах бүхнээ хийе гэсэн сэтгэл төрсөн. Түүнээс хойш олон гайхалтай номын андуудтай учирч, тэр учралуудын ачаар сэтгэл санаа минь ч өөдрөг болсон.

Одоо хүртэл өрөө төлж дуусаагүй байгаа ч өмнөхтэйгөө ялгаатай нь уурлаж, цухалдахаа байсан. Тулгарч буй асуудал бүхэн намайг өсгөж хөгжүүлэхийн төлөө бий болсон зүйл хэмээн хүлээн авдаг болсон. Тухайн үед намайг дэмжиж байсан номын андууддаа чин сэтгэлээсээ талархал илэрхийлье.

Мөн энэхүү гайхалтай байгууллагыг байгуулсан Үүсгэн байгуулагчдаа талархаж байна. Би сургаал номыг аль болох олон хүнд хүргэхийг зорьж, сургаал түгээж эхэлсэн. Төрсөн тосгон Чэндирпүни, Дакка, Читагон хотуудаар явж, олон хүнийг гишүүнээр элсүүлсэн. Одоогийн байдлаар гишүүний тоо 100 даваад байна. Хойшид ч сургаалыг илүү олон хүнд хүргэхийг хичээх болно.

Мөн нэг сайхан үйл явдал бол төрсөн тосгон Чэндирпүнид шинэ салбар нээгдэхээр болсон. Мөн Энэтхэгийн Колката болон Буддагаяа зэрэг олон газарт сургаалыг дагах хүний тоо

Spiritual Journey

нэмэгдэж байгаа гэж сонсоод баярладаг. Яагаад гэвэл тухайн үед өмнөд азийн салбарын ахлагч байсан Сайто гуайн заавраар Колката руу анх удаа сургаал түгээхээр очиход одоогийн салбарын ахлагч Шүмонтой танилцсан үе санаанд ордог болохоор юм. Шүмон Энэтхэгээс Бангладешт ирж бурханаа залж авч байсан. Би Колката руу сургаал түгээхээр 3 удаа явж байсан ба нийтдээ 36 хүнийг гишүүнээр элсүүлсэн. Одоо Колката салбар болон дэвшиж, Шүмон ч ахлагчийн үүргийг гүйцэтгэж байна. Колкатад байх үед тусалж байсан Шүмон ахлагчийн аав болон охин дүү Шүшшүмита нарт чин сэтгэлээсээ талархал илэрхийлье.

Хүн зөвхөн өөрийн аз жаргалыг бодоод байж болохгүй. Бусдын аз жаргалыг ч бодож явах хэрэгтэй. Илүү олон хүнийг аз жаргалтай болгохын тулд Үүсгэн байгуулагчийн сургаалыг сэтгэлдээ тээн, сургаалыг түгээхээр шамдах хэрэгтэй. Саяхан Аритомит тэргүүн Бангладеш нийгэмлэг байгуулагдсаны 20 жилийн ойг угтан сургаалыг өдий хүртэл түгээж ирсэн дээд үеийнхэнд талархаж, олон хүнд сургаалыг түгээхээр хичээе гэж хэлсэн. Би ч гэсэн хойшид сургаал номыг түгээхэд бүхий л хүч чадлаа дайчлах болно гэдгээ тангараглаж яриагаа өндөрлүүлье. Анхаарал тавин сонссон та бүхэнд баярлалаа.



Бимал Канти Баруа сургалтанд сууж байгаа нь

Living the
 **LOTUS**



Мэргэн отчийн үлгэр

Түүнчлэн ирсний насны хэмжээ
16-р бүлэг

Агуу билиг оюун төгөлдөр нэгэн оточ байжээ. Тэрээр эм найруулахдаа гаргуун бөгөөд ямар ч өвчнийг эдгээдэг алдартай оточ байв. Тэр оточ олон хүүхэдтэй байв. Нэг өдөр хүүхдүүд нь аавыгаа гадагш гарсан хойгуур андуураад хортой эм уучихжээ. Эм үйлчилж хүүхдүүд тэвчихийн аргагүй өвдөцгөөв. Яг тэр үед аав нь гэртээ харьж ирэхэд хүүхдүүд аавыгаа хараад ихэд баярлав.

Хүүхдүүд аавдаа юу болсныг ярьж, амь аврахыг гуйв. Аав нь шуудхан сайхан өнгө, үнэр, амттай эмийг нунтаглан холиод хүүхдүүддээ “энэ эмийг уувал өвчин эдгээд зогсохгүй дахиж өвдөхгүй болно” гэв.



Ухаан санаагаа алдаагүй байгаа зарим хүүхдүүд нь эмийг хурдхан авч уугаад эрүүл саруул болов. Харин эмийн уршгаар ухаан санаа балартсан хүүхдүүд нь эмийг уухад хэцүү хэмээн бодож, ууя ч гэхгүй байв.

Аав нь тэр хүүхдүүдээ хараад өрөвдөж, бүх хүүхдээ нэгийг ч үлдээлгүй аврах арга бодож олов. Ингээд хүүхдүүдээ эмийг заавал уугаарай хэмээн захиж үлдээгээд, дахин хол явав.



Удалгүй туслахаа гэр лүүгээ явуулж, өөрийгөө нас барсан гэж хэлүүлэв. Хүүхдүүд нь үүнийг сонсоод гашуудан шаналав. Тэгээд итгэж найдах хүнгүй болж, сэтгэлээр унаад ирэхийн цагт аавынхаа үлдээсэн эмийг санаж, ач тусыг нь ухаарав. Ухаан санаа балартаад эмийг уулгүй хоронд хордон зовж байсан хүүхдүүд нь ч эмийг авч уун, бүгд эрүүл саруул болов. Түүнийг мэдсэн аав нь гэртээ харьж, эрүүл саруул байгаагаа харуулав.



Тайлбар

Алдартай оточ аав нь Бурхан, хүүхдүүд нь хүмүүс бид юм. Хортой эм нь зовлонгийн эх үүсвэр болох шунал хүсэл (гурван хор: шунал, уур хилэн, мунхаг) ба сайн эм гэдэг нь бурханы сургаал (Цагаан лянхуа судар) болно.

Ялж төгс нөгчсөн Язгуурын Бурхан бол төрөхгүй, үхэхгүй бөгөөд үргэлж бидний дэргэд байдаг боловч хүмүүс бид түүнийг ухаарахгүй, нүдэнд харагдах түр зуурын зүйлд л автан, төөрөлдөн зовж байдаг.

Бурхан бүх юмс үзэгдэл шалтгаан, нөхцлийн харилцан холбоогоор үүсдэг хийсвэр зүйлээс өөрцгүй хэмээн айлдах ба энэ сургаалыг сонсож, ойлгосон хүмүүс шунал хүслээс ангижирч, амар амгаланг олж чаддаг.

Гэвч тэдгээр хүмүүс номын замд хөтлөн оруулсан Бурхан дэргэд нь байхгүй болмогц дураараа аашилж, сургаал номоос холдоод ирдэг. Бурхан багш үүнд санаа зовон айлдсан сургаал бол энэхүү үлгэр юм.

Аавыгаа эзгүйд андууран хортой эм ууж, өвдөн шаналж буй хүүхдүүд нь аавыгаа харьж ирэхийг хараад ихэд баярладаг. Энэ нь шунал хүсэлдээ төөрөлдөн байгаа хүмүүс бол бурханы үр хүүхэд учраас бурханыг хараад баярлах сэтгэл төрдөг болохыг илэрхийлнэ.

Бурхан зовж шаналж буй хамаг амьтныг аврахын тулд олон төрлийн эмийг хольж найруулан өнгө, үнэр, амт сайтай, хүн хүний нөхцөл байдалд таарсан уухад амар сайн эмийг бэлдэж өгдөг. Үүнд “нэг ч хүн үлдээлгүй бүх хүмүүсийг аварья” гэсэн Бурханы нигүүлсэхүй агуулагддаг.

Эмийг шуудхан уусан хүүхдүүд шиг бурханы сургаалыг байгаагаар нь шууд хүлээж авсан хүмүүс тэр дороо аз жаргалтай болох боловч сургаалыг тийм амар хүлээж авахгүй хүмүүс ч бий. Яагаад гэвэл тэдгээр хүмүүс шунал хүслийн улмаас сэтгэлийн төөрөгдөлд автагдсан байгаа тул хичнээн сайн эм өгсөн ч гэсэн уухад хэцүү хэмээн буруу бодоод уудаггүй байна. Өөрөөр хэлбэл өөрийн дураар амьдарч байгаа хүн бурханы үйл гэхээр дураараа амьдарч чадахгүй мэт бодогдож, хүний төлөө гэсэн бодисадвагийн үйл хийхээс төвөгшөөдөг байна.

Бурхан тийм хүмүүсээс хэсэг хугацаанд холддог. Үүнийг түүхэн талаас аваад үзэх юм бол энэ ертөнцөд хүн болж мэндэлсэн Шагжамүни бурхан багш насан өөд болсныг илэрхийлнэ. Шагжамүни бурхан багшийг өөд болсны дараа сэтгэлээр унасан хүмүүс “яаж ийгээд өөрийн хүчээр босох хэрэгтэй” хэмээн ухаардаг. Сүсэг бишрэлд өөрөөсөө сургаал номыг эрэлхийж, хэрэгжүүлэх чухал байдаг. Үүнийг ойлгуулахын тулд Бурхан багш өөрийгөө далдалсан юм.

Эцэст нь хүүхдүүд эмийг ууж, ухаан санаа хэвийн болох үед өөд болсон гэж бодож байсан аав нь гарч ирдэг. Энэ нь хүмүүс бид бурханы сургаалыг өөрөөсөө эрэлхийлж, үнэн сэтгэлээсээ итгэж сүсэглэх юм бол Бурхан харагддаг гэсэн утгатай. Өөрөөр хэлбэл Бурхан үргэлж бидний дэргэд байдаг гэдгийг ойлгоно гэсэн үг юм.

Чюүо эрдэм шинжилгээний институт



Тайлбарт Нивано Никкёогийн «Цагаан Лянхуа Сударын шинэ тайлбар» болон «Лянхуан Гурамсан Сударын шинэ тайлбар» номыг ашигласан болно.




Энэрэнгүй сэтгэлээр

Өнгөрсөн 4 сарын 29 нд Токиогийн эрэгтэйчүүдийн бүлгийн санаачлагаар нураах шийд гараад байгаа Фүмон барилгад зориулсан талархалын номын хурал зохион байгуулагдав.

Номын хурлын өмнө Уран арга бүлэгт гардаг “таван мянган босон одогсод”-той холбоотой, Фүмон барилгыг байгуулсан шалтгааны тухай тайлбарласан үүсгэн байгуулагчийн дүрст бичлэгийг үзүүлэв. Агуулга нь “таван мянган хүний багтаамжтай том танхим байгуулсан нь Бурхан Будда багшийн сургаалыг дутуу сонссон гэдгээ анзаарсан хүмүүст зориулж томоос том хаалга нээж, Цагаан Лянхуа судрын сургаалыг чөлөөтэй сонгохын төлөө” гэж хэлэв. Би үнэхээр гайхав. Үүсгэн байгуулагчийн энэрэнгүй сэтгэл ямар аугаа юм бэ? Сэтгэл маш их хөдлөв.

Ерөнхийлөгчийн энэ сарын сургаалаас “энэрэнгүй сэтгэлээр бодох” тухай суралцаад, улмаар Үүсгэн байгуулагчийн адил үргэлж бусдын төлөө боддог энэрэнгүй сэтгэлтэй хүн болмоор байна гэж бодов. Ийнхүү дахин тангараглав.

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Саитоо Кооичи



RISSHO KOSEI-KAI INTERNATIONAL BRANCHES



We welcome comments on our e-newsletter Living the Lotus. Please send us your comments to the following e-mail address.
E-mail: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

2018

Rissho Kosei-kai International

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First Street Suite #1 Los Angeles CA 90033 U.S.A.
Tel: 1-323-262-4430 Fax: 1-323-262-4437
e-mail: info@rkina.org http://www.rkina.org

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way,
WA 98003 U.S.A.
Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
e-mail: rkseattlewashington@gmail.com
http://buddhistlearningcenter.org/

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
P.O. Box 692148, San Antonio, TX78269, USA
Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
e-mail: dharmasanantonio@gmail.com
http://www.rkina.org/sanantonio.html

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Road, Clearwater, FL 33764, U.S.A.
Tel: (727) 560-2927 e-mail: rktampabay@yahoo.com
http://www.buddhismtampabay.org/

Rissho Kosei-kai of Vancouver

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
e-mail: info@rkhawaii.org http://www.rkhawaii.org

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.
Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona,
HI 96740 U.S.A.
Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
e-mail: rk-la@sbcglobal.net http://www.rkina.org/losangeles.html

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado
Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego
Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas
Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437
e-mail: info@rksf.org http://www.rksf.org

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016 U.S.A.
Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
e-mail: rkny39@gmail.com http://rk-ny.org/

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056 U.S.A.
Tel: 1-773-842-5654 e-mail: murakami4838@aol.com
http://home.earthlink.net/~rkchi/

Rissho Kosei-kai of Fort Myers

http://www.rkftmyersbuddhism.org/

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112 U.S.A.
Tel & Fax: 1-405-943-5030
e-mail: rkokdc@gmail.com http://www.rkok-dharmacenter.org

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

1255 Galapago Street, #809 Denver, CO 80204 U.S.A.
Tel: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

425 Patterson Road, Dayton, OH 45419 U.S.A.
http://www.rkina-dayton.com/

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060 Brasil
Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377
Fax: 55-11-5549-4304
e-mail: risho@terra.com.br http://www.rkk.org.br

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000 Brasil
Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjheng District,
Taipei City 100 Taiwan
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433
http://kosei-kai.blogspot.com/

Rissho Kosei-kai of Taichung

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District,
Tainan City 701 Taiwan
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Rissho Kosei-kai of Pingtung

Korean Rissho Kosei-kai

6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Busan

3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,
North Point, Hong Kong, Republic of China

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

15F Express tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
Tel: 976-70006960 *e-mail:* rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation
Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29-00184 Roma, Italia
Tel & Fax : 39-06-48913949 *e-mail:* roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK

Rissho Kosei-kai of Venezia

Rissho Kosei-kai of Paris

International Buddhist Congregation (IBC)

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibc-rk.org/>

Rissho Kosei-kai of South Asia Division

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Branches under the South Asia Division

Rissho Kosei-kai of Central Delhi

224 Site No.1, Shankar Road, New Rajinder Nagar, New Delhi,
110060, India

Rissho Kosei-kai of West Delhi

66D, Sector-6, DDA-Flats, Dwarka, New Delhi 110075, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road
Rumpur, Gaya-823001, Bihar, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Phnom Penh

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Rissho Kosei-kai of Singapore

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218 *e-mail:* info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai of Dhaka

House#408/8, Road#7(West), D.O.H.S Baridhara,
Dhaka Cant.-1206, Bangladesh
Tel: 880-2-8413855

Rissho Kosei-kai of Mayani

Mayani(Barua Para), Post Office: Abutorab, Police Station: Mirshari,
District: Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Ume Burmese Market, Main Road Teck Para, Cox'sbazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Ramu

Rissho Kosei Dhamma Foundation, Sri Lanka

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
Tel: 94-11-2982406 *Fax:* 94-11-2982405

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Other Groups

Rissho Kosei-kai Friends in Shanghai